



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн
Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

Хөтөлбөрийн нэр: Уламжлалт анагаах ухаан

Индекс: E09170101

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Мөнхтуяа

Гишүүд: У.Мягмаржав

Д.Амарзаяа

Он сар өдөр: 2021.01.18-19

Агуулга

Товчилсон үгийн тайлбар	4
I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт	6
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга	7
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн зорилго, агуулга	8
Шалгуур 2: Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт	13
Шалгуур 3: Суралцахуйн үнэлгээ, хөгжил	18
Шалгуур 4: Багшлах бүрэлдэхүүн	25
Шалгуур 5: Нөөц ба санхүүжилт	29
Шалгуур 6: Удирдлага ба мэдээллийн систем	32
Шалгуур 7: Чанарын баталгаажуулалт	36
IV. Уулзалтад оролцогчдын нэрс	
I. Оюутнуудын нэрс	42
II. Төгсөгчдийн нэрс	42
III. Ажил олгогчдын нэрс	43
IV. Багш нарын нэрс	43
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал	44
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	45
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	45

Товчилсон үгийн тайлбар

МОНГОЛ ҮГС	
АУ	Анагаах ухаан
АУС	Анагаах Ухааны Сургууль
АУБС	Анагаах ухааны боловсрол судлал
АУИС	Анагаах Ухааны Их Сургууль
АУДэС	Анагаах Ухааны Дээд Сургууль
АУТНС	Анагаах Ухааны Төв Номын Сан
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АХБ	Азийн Хөгжлийн Банк
АШУ	Анагаахын шинжлэх ухаан
АШУУИС	Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль
БАС	Био-Анагаахын Сургууль
БМИҮЗ	Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний зөвлөл
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БС	Боловсрол судлал
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам
БСШУСЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам
БХТ	Багшийн хөгжлийн төв
БШУ	Боловсрол, шинжлэх ухаан
ГХХАГ	Гадаад Харилцаа Хамтын Ажиллагааны Газар
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ДӨСТ	Дотор өвчин судлалын тэнхим
ЗГ	Засгийн газар
ЗТЗТ	Зүү төөнө заслын тэнхим
ИДС	Их дээд сургууль
ИС	Их сургууль
ИСУТС	Их сургуулийн удирдлага, технологийн систем
ИХШХЕГ	Иргэний Харьяалал, Шилжилт Хөдөлгөөний Ерөнхий Газар
МАУ	Монгол анагаах ухаан
МАУОУС	Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль
МАУСТ	Монгол анагаах ухаан судлалын тэнхим
МТА	Мэдээлэл технологийн алба
МУАУУТ, МЯЭ	Монголын Уламжлалт Анагаах Ухааны Үндэсний Төв, Монгол Японы Эмнэлэг
МУИС	Монгол Улсын Их Сургууль
НЭМС	Нийгмийн Эрүүл Мэндийн Сургууль
ОН	Магистрын Нийгэмлэг
ОУ	Олон улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨМОУЭХ	Өвөр Монголын Олон Улсын Эмнэлгийн Хороо
ӨМӨЗО, БНХАУ	Өвөр Монголын Өөртөө Засах Орон,
ӨМҮИС	Өвөр Монголын Үндэстний Их сургууль

СБЗГ	Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
СЭЗГ	Санхүү Эдийн Засгийн Газар
ТСБЗГ	Төгсөлтийн Сургалтын Бодлого Зохицуулалтын Газар
ТСЗ	Төрийн Сангийн Зээл
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
УАУ	Уламжлалт анагаах ухаан
УАУТХ	Уламжлалт Анагаах Ухаан, Технологийн Хүрээлэн
УБЗТ	Уламжлалт бариа заслын тэнхим
УЖСТ	Уламжлалт жор судлалын тэнхим
УЭТ	Уламжлалт эмчилгээний тэнхим
ШУ	Шинжлэх ухаан
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль
ШУТС	Шинжлэх Ухаан Технологийн Сан
ЭЗ	Эрдмийн зөвлөл
ЭЗС	Эм-Зүйн Сургууль
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
ЭМСА	Эрдмийн болон Мэргэжлийн Сургалтын Алба
ЭМХТ	Эрүүл Мэндийн Хөгжлийн Төв
ЭМШУИС	Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль
ЭМЯ	Эрүүл Мэндийн Яам
ЭС	Эрдмийн Сургууль
ЭСТ	Эрдмийн сургалтын тэнхим
ЭШ	Эрдэм шинжилгээ

АНГЛИ ҮГС

CAJMS	Central Asian Journal of Medical Sciences
ERP	Enterprise resource planning
EMS	Emergency medical services
IELTS	International English Language Testing System
ISSN	International Standart Serial Number
IF	Impact Factor
IMSAC	International Medical Science Asian Conference
KIOM	Korean Institute of Oriental Medicine
Ph.D	Doctor of Phylosophy
PBL	Problem-based learning
SWOT	Strengths, Weaknesses, Opportunities, Threats
Sc.D	Science Doctor
TAU	Tokyo Ariake University
TOEIC	Test of English for International Communication
TOEFL	Test of English as a Foreign Language
QS	Quantity specification
WPRIM	Western Pacific Region Index Medicus

I. Хөндлөнгийн үнэлгээ хийх үйл явц, төлөвлөлт

Сургуулийн нэр /Монгол, Англи/	АШУҮИС-ийн Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль	
Сургалтын хөтөлбөрийн нэр /Монгол, Англи/	“Уламжлалт анагаах ухаан” магистрын хөтөлбөр	
Индекс	E09170101	
Шинжээчид	<p>Ахлагч: Ц.Мөнхтуяа - Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн магистр, докторын сургалтын албаны дарга</p> <p>Гишүүд: У.Мягмаржав – Боловсролын хүрээлэнгийн Дээд болон мэргэжлийн боловсролын судалгааны секторт Бакалаврын хөтөлбөрийн агуулга, судалгаа хариуцсан Эрдэм шинжилгээний ажилтан</p> <p>Д.Амарзаяа Уламжлалт анагаах ухааны технологийн хүрээлэнгийн эрүүл мэнд, тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга</p>	
БМИҮЗ-ийн Мэргэжилтэн	Магадлан итгэмжлэл хариуцсан шинжээч - Б.Мядагмаа	
Төлөвлөгөө	Он сар өдөр	Хийгдсэн байх ажлууд /Мэргэжилтний гаргаж өгсөн хуваарийн дагуу бичнэ/
	2020.12.16	Тайлан хүлээн авч гэрээ хийсэн
	2020.12.21	Урьдчилсан үнэлгээний тайланг илгээв.
	2021.01.18	Сургууль дээр очиж ажиллах
	2021.01.19	Багш, суралцагч, ажил олгогч, төгсөгчидтэй
	2021.01.20	Шинжээчид магадлан итгэмжлэлд орж буй сургуульд өөрсдийн тайланг илгээх
		Сургууль шинжээчийн тайлантай танилцаж хариу өгч, шинжээчийн тайлан эцсийн байдлаар бэлэн болох
		Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр гарах
Шалгуур шаардлага /журам/		

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Уламжлалт анагаах ухааны магистр бэлтгэх төгсөлтийн сургалт нь 1994 оноос эхлэн дээд боловсролын салбарт хэрэгжиж, Монгол Улсын эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүний нөөцөд уламжлалт анагаах ухааны магистр хэмээх ахисан шатны шинэ мэргэжилтэн 1995 оноос ажиллаж эхэлсэн байна.

"Уламжлалт анагаах ухаан" магистрын хөтөлбөр нь хүн амын эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлага, эмнэлгийн тусламж, эмнэлгийн үйлчилгээний бодлоготой уялдуулан УАУ-ны түүх, эх сурвалж, эмийн ургамал, жор найрлагын фармакологи, эмнэл зүй болон сорил туршилтын арга зүйг эзэмшиж зонхилон тохиолдох өвчин эмгэгийг монгол болон орчин цагийн анагаах ухааны аргуудаар урьдчилан сэргийлэх, асуудлыг тодорхойлж, баримт нотолгоонд үндэслэн дүн шинжилгээ хийж, зүй тогтлыг илрүүлэх, тандан судлах, хөгжлийн хандлагыг тодорхойлох, таамаглал дэвшүүлэн харьцуулсан судалгаа, анализ хийх, загварчилж баримт бичиг боловсруулах, шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг үнэлж ухамсарладаг, мэргэжлийн болон судлаачийн ёс зүйтэй, тасралтгүй судалгаа хийж, идэвхтэй судлаач байж шинэ мэдлэг, мэдээллийг бий болгон шинжлэх ухаанд хувь нэмрээ байнга оруулах, мэргэжсэн мэргэжилтэн бэлтгэхэд чиглэнэ.

АШУҮИС-ийн МАУОУС-ийн төгсөлтийн сургалт нь эрүүл мэндийн төрөлжсөн судлагдахуунаар магистрын зэрэг олгох хөтөлбөрт суурилсан сургалт бөгөөд Монгол Улсын "Дээд боловсролын тухай" хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалт, БШУ-ны сайдын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хавсралтуудаар батлагдсан "Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам"-ын үзэл баримтлалд нийцсэн, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын сургалтын тусгай зөвшөөрөл бүхий хөтөлбөрөөр магистрын сургалт эрхлэхийг дэмжих, суралцагчдын боловсролын ба эрдмийн эрх чөлөөг хангахад чиглэгдэн хэрэгжиж байна.

Тус хөтөлбөрийн гол үзэл санаа нь Монгол анагаах ухаан, орчин үеийн анагаах ухааны нэгдмэл тэнцвэртэй байдлыг ханган зөв хослуулах, үндсэн уламжлалаа хадгалах гэж томъёологдсон. МАУОУС нь Монгол Улсын ерөнхийлөгч, Улсын Их Хурлаас Уламжлалт анагаах ухааныг 1999-2015 хөгжүүлэх төрийн бодлого, ДЭМБ-ын 2003 онд батлагдсан УАУ-ыг хөгжүүлэх стратегийг, ЭМЯ-ны сайдын 2010 онд баталсан "Монголын уламжлалт анагаах ухааныг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг мөрдлөг болгон, Өрнө-Дорнын анагаах ухааныг зөв зохистой хослуулан хөгжүүлж, I-III шатлалын эмнэлэгт ажиллах боловсон хүчнийг бэлтгэх зорилгын дагууд магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр уламжлалт эм, бэлдмэл гарган авах судалгаа шинжилгээг тэргүүлэх чиглэл болгон ажиллаж байна.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн зорилго, агуулга

Дээд боловсролын болон сургуулийн зорилго, мэргэжлийн салбарын судалгаа ба хөгжлийн бодлоготой уялдуулан оролцогч талуудын эрэлт хэрэгцээг тусган хөтөлбөрийн зорилго, агуулгыг шинэчлэн, хөтөлбөрийн чанарыг байнга сайжруулдаг байна

1.1 Хөтөлбөрийн баримт бичиг

Дээд боловсролын хууль эрх зүй, магистрын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага, хэрэглэгч ба оролцогч талуудын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулж, хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор жил бүр хянан үнэлдэг байна. Магистрантын сургалт болон судалгаа, хөгжил, бүтээлч ажлуудын төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ, чанарын баталгаажуулалтын арга барил нь хувь хүний болон мэргэжлийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн чөлөөт сонголт бүхий олон хувилбартай хэрэгждэг байна

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн 2020 оны 6 сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалаар батлагдсан “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”
- Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Номхон Далайн Баруун Эргийн УАУ-ны Бүсийн Стратеги (2014-2025)
- АШУҮИС-ийн 2015 оны 10 сарын 15-ны өдрийн А/117 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаал
- БШУ-ны сайдын 2014 оны 9 сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”,
- АШУҮИС-ийн 2011 оны 09 сарын 16-ны өдрийн А/53 тоот тушаалаар батлагдсан “Магистрын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрэм”
- АШУҮИС-ийн “Уламжлалт анагаах ухаан” магистрын сургалтын хөтөлбөр

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- 1995 оноос эхлэн УАУ хөтөлбөрөөр магистрын сургалтыг эхлүүлсэн ба 25 жилийн хугацаанд нийт 144 магистр төгсгөснөөс сүүлийн 5 жилд 67 төгсөгч хамгаалсан нь АШУҮИС дотроо бусад мэргэжлийн сургуультай харьцуулахад төгсөлтийн хувь өндөр буюу 86%-тай байгаа зэргээс харахад тухайн хөтөлбөр тогтвортой хэрэгжих бүрэн боломжтой байна.
- Сургалтын хөтөлбөрийн зорилгыг тодорхойлохдоо ДЭМБ-ын стратегид тулгуурлан Монгол анагаах ухаан, орчин үеийн анагаах ухааны нэгдмэл тэнцвэртэй байдлыг ханган зөв хослуулах, үндсэн уламжлалаа хадгалсан, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн орчин үеийн судалгааны арга зүйг эзэмшсэн энэхүү хоёр анагаах ухааны нэгдмэл чанарыг хангасан төгсөгч бэлтгэн гаргана гэж томъёолж сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөртөө бүрэн тусган хэрэгжүүлж байна.
- Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийж 2014, 2016, 2020 онуудад сургалтын төлөвлөгөөг багц цагийн хэмжээ, хичээлийн төрөлд өөрчлөлт оруулж хичээлийн агуулгын давхардлыг бууруулж чадсан байна.
- Төгсөгчийн загварыг ерөнхийд нь гаргаж төгсөгчийн давуу тал, мэдлэг, чадвар, хандлагыг тодорхойлсон байна.
- АШУҮИС-ийн Чанарын баталгаажилтын алба, СБЗА, Хөтөлбөрийн хороо, тухайн сургуулийн тэнхмийн эрхлэгчийн зүгээс хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ өгч хяналт тавьдаг тогтолцоонд шилжсэн.

- Хөтөлбөрийн баримт бичигт тасралтгүй сайжран ажиллах боломжийг бий болгодог Э.Деймингийн PDCA- эргэх процессоор боловсруулсан нь давуу талтай.
- Магистрын нэг сэдэвт бүтээл туурвих багц цагийг 2020 оны сургалтын төлөвлөгөөнд 14 багц цаг болгон нэмэгдүүлсэн нь судлаачийн судалгааны ажлын арга зүй, загвараа тодорхойлох, хэвлэлийн тойм бичих, судалгааны үр дүнгээ зохих шатны хурлуудаар хэлэлцүүлж жинхэнэ хамгаалалт хийх байдлыг бодитой үнэлэх боломжийг нэмэгдүүлсэн.
- Хөтөлбөрийн хэрэгжүүлэх үндсэн субъект болох багшийн ажлын тайланг үндэслэн тэнхим, бүрэлдэхүүн сургууль, АШУҮИС захирлын зөвлөл, Удирдах зөвлөлд тайлагнах улмаар эргээд нийт багш ажилчдад тайланг нэгтгэн танилцуулж саналыг авч дараа жилийн төлөвлөгөөнд тусгах байдлаар эргэх холбоотой ажиллаж чаддаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, алсын харааг тодорхойлсон арга аргачлал, хэрхэн хэрэгжүүлэх арга замыг тодорхой болгох тухайлбал сургалтын төлбөрөөс хараат бус санхүү, эдийн засгийн тогтвортой бүтцийг бий болгох гэж томъёолсон ч санхүүгийн чадамжийг сайжруулах гарц, гаргааны талаар дурдаагүй.

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөр хэрэгжилтийн үр дүн, явцын ажиллагаанд хяналт хийх байдлыг тогтмолжуулах, жил бүр хянадаг тогтолцоонд шилжих.

1.2 Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн төгсгөлд магистрантын эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал буюу суралцахуйн зорилтот үр дүнгээр хөтөлбөрийн зорилгыг тодорхойлсон байна. Хөтөлбөрийн зорилго нь үндэсний болон глобал хөдөлмөрийн зах зээлийн шинэ эрэлт хэрэгцээ, сургуулийн зорилгод нийцсэн (өөрийн сургуулийн магистрын сургалтын онцлог, давуу байдлыг тусгасан) байна. Суралцахуйн зорилтот үр дүнг тодорхойлоход хэрэглэгч ба оролцогч талуудыг татан оролцуулж, тэдний эрэлт хэрэгцээ, шаардлагыг тусгасан байна..

Илрэл нотолгоо:

- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Хөгжлийн Бодлого 2015-2024
- Монгол Анагаах Ухаан Олон Улсын Сургуулийн хөгжлийн бодлогын /2014-2019/ дунд хугацааны төлөвлөлтийн биелэлт, Ирээдүйн төлөвлөгөө /2020-2025/
- АШУҮИС-ийн “Уламжлалт анагаах ухаан” чиглэлийг магистрын сургалтын хөтөлбөрүүд
- АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- АШУҮИС-ийн Судалгааны хүрээлэн, төв, лабораторийн нэгдсэн журам
- АШУҮИС-ийн Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн санхүүжилтийн дотоод журам
- АШУҮИС-ийн Шинжлэх ухаан, технологийг дэмжих сангийн тухай журам
- АШУҮИС-ийн Технологи дамжуулах журам
- АШУҮИС-ийн Барааны тэмдгийг ашиглах тухай журам
- АШУҮИС-ийн Оюуны өмчийн талаар баримтлах бодлого

- Эрдэм шинжилгээний төсөл, хөтөлбөр, захилгат ажлын санхүүжилтээс АШУҮИС-д шинжлэх ухаан, технологи, инновацийг дэмжих хуримтлал бүрдүүлэхэд баримтлах журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУСургууль эрхэм зорилгоо тодорхойлохдоо АШУҮИС-ийн эрхэм зорилготой уялдуулж “Олон Улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг, үндэсний тэргүүлэх, Номхон Далайн Баруун Эргийн Бүсийн анагаах ухааны шилдэг 100 их сургуулийн нэг байхад оршино” хэмээн тодорхойлсон АШУҮИС-ийн эрхэм зорилготой уялдуулан МАУОУС-ийн эрхэм зорилгыг “Уламжлалт анагаах ухааны сургалтыг олон Улсын шинэ түвшинд гарган, хүний нөөцийг чадавхжуулан, эмнэлзүйн удирдамж, технологийн шинэчлэл бүхий уламжлалт эм, бэлдмэлийг гарааны компани байгуулан үйлдвэрлэх замаар эмнэлэг үйлчилгээний ашиг орлогыг нэмэгдүүлэн, судалгааны их сургуулийн QS шалгуурт тэнцэх” хэмээн тодорхойлжээ.
- УАУ-ы сургалтыг олон улсын шинэ түвшинд гаргах, хүний нөөцийг чадавхжуулан, эмнэлзүйн шинэ удирдамж, технологийн шинэчлэл бүхий уламжлалт эм, бэлдмэлийн гарааны компани байгуулан үйлдвэрлэх замаар эмнэлэг үйлчилгээний ашиг орлогыг нэмэгдүүлэн ИС-ийн QS шалгуур (академик нэр хүнд, хүний нөцийн чадавх, оюутан багш, хэвлэл өгүүлэл, гадаад зочин багш, гадаад оюутан)т тэнцэх гэж тодорхойлсон байна.
- АШУҮИС-ийн Эрдэм шинжилгээ, судалгааны тэргүүлэх чиглэлтэй уялдуулж эмнэл зүйн судалгаанд суурилж сургалтын санхүүжилтээс судалгааны санхүүжилтэд түшиглэсэн их сургууль болно гэж тодорхойлоод энэ дагууд судалгааны сургууль болох нөхцөлийг бий болгосон байна гэж үзэхээр байна.
- Сургалтын эхлэл ба төгсгөлд суралцагчдаас санал асуумж авч сургалтын хөтөлбөрт үнэлгээ өгдөг, түүнчлэн ажил олгогчдоос 7 асуумж бүхий асуулга авч хөтөлбөрийн үйлчилгээний чанарт SERVQUAL аргачлалаар үнэлдэг.

1.3 Хөтөлбөрийн агуулга

Хөтөлбөрийн агуулга нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад чиглэсэн байна. Хөтөлбөрийн агуулга нь мэргэжлийн ахисан түвшиний судалгааг хөгжүүлэхэд чиглэх ба онол практикийг зохистой хослуулан, логик дэс дараалалтай, давхардалгүй хэрэгжүүлэх сургалтын болон судалгааны төлөвлөгөөг боловсруулж, заавал болон сонгон суралцах агуулга, сургалтын хэлбэрийг зохистой тогтоож, мөрддөг байна.

Илрэл нотолгоо:

- Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Хөгжлийн Бодлого 2015-2024
- Монгол Анагаах Ухаан Олон Улсын Сургуулийн хөгжлийн бодлогын /2014-2019/ дунд хугацааны төлөвлөлтийн биелэлт, Ирээдүйн төлөвлөгөө /2020-2025/
- АШУҮИС-ийн “Уламжлалт анагаах ухаан” чиглэлийн магистрын сургалтын хөтөлбөр
- АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүдийг Дээд боловсролын тухай хууль, БСШУ-ы Сайдын тушаал, удирдамж заавартай уялдуулан 3 удаа шинэчилж, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хичээлүүдийн зохист харьцааг бий болгож, хичээл бүрийг лекц, дадлага хослуулсан байдлаар суралцагч нийт багц цагийн 50 хүртэл хувийг бие даан судлах байдлаар төлөвлөж хэрэгжүүлж байна.
- Хөтөлбөрийн агуулгыг тодорхойлохдоо монголын уламжлалт анагаах ухааны чиглэлээр онолын чиглэлийн, эмийн жорын эмчилгээний үйлдлийн талаарх туршилт судалгаа, эмийн клиникийн буюу эмнэлзүйн туршилт судалгаа хийх гэсэн үндсэн 3 чиглэлд суурилсан хичээлүүдийг хичээлийн 4 семестрт уялдуулан байршуулсан, ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн харьцаа нь 26.8%: 24,4%: 48.8% байхаар сургалтын төлөвлөгөөнд тусгажээ.
- Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрүүд нь суралцахуйн зорилтот үр дүнд хүрэхэд чиглэсэн харилцан уялдаатай хэрхэн үр дүнтэй хэрэгжиж байгаад МАУОУС-ийн “Хөтөлбөрийн дэд хороо”, АШУҮИС-ийн “Эрдмийн сургууль”, “Төгсөлтийн сургалтын алба”-наас хяналт тавьж ажилладаг, түүнд үндэслэн шинэчлэлт хийж ирсэн. Хамгийн сүүлд 2020 онд магистрын хөтөлбөрт өөрчлөлт оруулж батлуулан хэрэгжүүлж байна.
- “Уламжлалт анагаах ухаан” магистрын хөтөлбөрийн шаардлагын дагуу суралцагчийн мэдлэг, чадвар, хандлагыг олгох, ур чадварыг сайжруулах, бие даан шийдвэр гаргах, судалгаа хийх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор суралцах хэлбэрийн хувьд суралцагч нийт багц цагийн 50 хүртэл хувийг бие даан судлахаар заасан байна.
- Хичээлийн логик дэс дарааллын хувьд 1-р дамжаанд суурь хичээлүүд болох Судалгааны арга зүй, Судалгааны ажлын ёс зүй, Эпидемиологи, Биостатистик, Мэргэжлийн англи хэлний хичээлүүд, 2-р дамжаанд тухайн судалгааны чиглэлтэй холбоотой мэргэшүүлэх хичээлүүд байршжээ.
- Судалгааны ажлын дээрх 3 чиглэлээр магистрын хамгаалалтууд хийгдэж байгаа нь хичээлүүдийн сонголт төрөл нь хөтөлбөр хэрэгжихэд бүрэн нийцэж байгаа нь харагдлаа.

Анхаарах асуудал:

- Хичээлүүдийн уялдаа холбоог дахин харж үзэх, төгсөгч, суралцагчдын саналыг тусгах

Зөвлөмж:

- Хичээлийн уялдаа холбоог судалгааны ажлын явцтай уялдуулж байршуулах, тухайлбал судалгааны ажлын боловсруулалт, биостатистик, судалгааны ажлын арга зүй зэрэг НЭМ-ийн сургуулиас ордог хичээлүүдийг 2-р курсын эхэнд оруулж байх саналыг АШУҮИС-д уламжлан шийдвэрлүүлэх

1.4 Хичээлийн хөтөлбөрүүд

Сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх хичээл бүрийн хөтөлбөрийг иж бүрэн боловсруулсан байна. Үүнд: тухайн хичээлийг судлах үндэслэл, урьдач нөхцөл, уялдаа холбоо, суралцахуйн зорилтот үр дүн, хичээлийн агуулга, багц цаг, магистрантын суралцахуйн ачаалал, үнэлгээний аргачлал зэргийг дэлгэрэнгүй багтаасан байна. Хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын мэргэжлийн болон хөрвөх ур чадварыг хөгжүүлэхэд чиглэх ба тэдгээрийг суралцагчдад ил тод мэдээлдэг, шаардлагатай тохиолдолд гарын авлага

болгон хэвлэсэн байна. Магистрант нь хувь хүний хөгжлийн болон судалгааны ур чадвараа хөгжүүлэх боломжийг хичээлийн хөтөлбөрүүдэд тодорхой тусгасан байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Илрэл нотолгоо:

- Сургалтын төлөвлөгөөн дэх хичээлийн хөтөлбөрүүд
- АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Багш нарын жилийн ажлын төлөвлөгөө
- Багшийн ажлын хавтас
- БШУ-ны сайдын 2014 оны 9 сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”
- АШУҮИС-ийн “Суралцагчийг үнэлэх журам” 2015 оны 12 сарын 15-ний өдрийн А\144 хавсралт 1-ээр СБЗГ-ын баталсан “Суралцагчийг үнэлэх журам”
- АШУҮИС-ийн 2016 оны 1 сарын 22-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Уламжлалт анагаах ухаан” сургалтын хичээлийн хөтөлбөрүүд нь суралцагчдын судалгаа шинжилгээ хийх мэдлэг, ур чадварыг улам сайжруулж, хувь хүний хөгжлийг дэмжсэн, хөтөлбөрт тавигдах шаардлагын дагуу боловсрогдсон байна.
- Сургалтын төлөвлөгөөнд 2 удаа өөрчлөлт оруулсан үүний дагуу хичээлийн агуулга, хичээлийн нэр төрөл нь суралцагчийн сурч мэдэх хэрэгцээ зорилготой хэрхэн нийцэж буйд үнэлгээ хийхэд магистрантын хувь хүний хөгжил, судалгааны ур чадвар дээшлэхэд эерэгээр нөлөөлсөн гэсэн дүгнэлтийг өгсөн байна.
- Магистрын сургалт эхлэхийн өмнө болон дууссаны дараа сургуулийн зүгээс магистрант суралцагчидтай уулзаж хичээлийн хөтөлбөр, сургалтын явцын талаар санал солилцож явцын үнэлгээ хийдэг.

1.5 Хөтөлбөрт тавих тусгай шаардлага

Хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүн, агуулга нь тухайн хөтөлбөрийн хамаарах ерөнхий, төрөлжсөн, нарийвчилсан чиглэлээр Мэргэжлийн зөвлөлөөс тогтоосон тусгай шаардлагыг хангасан байхаас гадна үндэсний болон олон улсын сайн туршлагыг нутагшуулахыг эрмэлзэнэ.

Илрэл нотолгоо:

- Орегон Уламжлалт Анагаах Ухааны сургуулийн сургалтын төлөвлөгөө
- Тяньжин Хятад Уламжлалт Анагаах Ухаан сургуулийн магистрын диплом
- Хар мөрөн мужийн Уламжлалт анагаах ухааны их сургуулийн магистрын диплом
- Шанхай Уламжлалт Анагаах Ухааны Их Сургууль
- БНХАУ-ын ӨМҮИС-ийн сургалтын төлөвлөгөө
- АШУҮИС-ийн Уламжлалт анагаах ухаан магистрын сургалтын хөтөлбөр (2016)

- Оточ Манрамба Их Сургуулийн магистрын диплом
- Шинэ Анагаах Ухаан Их Сургуулийн сургалтын төлөвлөгөө
- Эм зүйн Шинжлэх Ухааны Их Сургуулийн магистрын сургалтын төлөвлөгөө
- Этүгэн Их Сургуулийн магистрын диплом

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУС нь хэрэгжүүлж буй Уламжлалт анагаах ухаан магистрын хөтөлбөрийг АНУ-ын Орегон мужийн Уламжлалт Анагаах Ухааны сургуулийн магистрын хөтөлбөр, БНХАУ-ын Тяньжин Хятад УАУ-ы сургууль, Хар мөрөн мужийн УАУ-ы их сургууль, Шанхайн УАУ-ы их сургууль, ӨМӨЗО-ы ӨМҮИС-ийн УАУ-ы магистрын хөтөлбөр, түүнчлэн дотоодын 4 сургууль (Оточ Манрамба Их сургууль, Шинэ Анагаах Ухаан Их Сургууль, Эм зүйн Шинжлэх Ухааны Их Сургууль, Этүгэн Их Сургууль)-ийн хөтөлбөртэй харьцуулалт хийж төлөвлөгөөнд тусгагдсан хичээлийн агуулга, хичээлийн тоо, нийт кредит, суралцах хугацаа, мэргэжлийн нэр зэрэг үзүүлэлтээр ижил болон ялгаатай талыг ӨМӨЗО-ны их сургуулиудын хөтөлбөртэй харьцуулахад хичээлийн багц цаг болон агуулгын хувьд ойролцоо байна.
- Уламжлалт анагаах ухаан магистрын хөтөлбөр нь танхимын болон цахим орчинд суурилж англи, монгол хэлээр явагддаг тул гадаад суралцагсдад суралцах боломжтой, олон улсын чиг хандлагад ойртсон гэж үзэхээр байна.
- Дотоодын 4 сургуулийн хөтөлбөртэй харьцуулан үзэхэд Оточ Манрамба ИС болон Этүгэн ИС-ийн УАУ-ны магистрын хөтөлбөртэй төстэй. Шинэ анагаах ухаан Их Сургууль, Эм зүйн Шинжлэх Ухааны их сургуулийн хувьд хичээлийн агуулга нэр төрлийн хувьд өөр өөрийн сургуулийн сургалтын өвөрмөц онцлогийг харуулсан хөтөлбөрөөс өөр байна.
- МАУОУС-ийн УАУ-ны хөтөлбөр нь орчин үеийн нийгмийн хэрэгцээ, ажлын байранд тавигдах мэдлэг, ур чадварыг хангасан, дэлхийн АУ-ны боловсролын мэргэжилтэн бэлтгэх суурь стандарт, Монгол Улсын хууль тогтоомж, журам, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагад бүрэн нийцсэн, хувь хүний хөгжил, бүтээлч чанаруудыг нэмэгдүүлэх хөтөлбөр гэж үзэж байна.
- “Уламжлалт анагаах ухаан” сургалтын хөтөлбөрийн агуулга нь суралцагчдын академик эрх чөлөөг хангахуйц, уламжлалт анагаах ухааны онцлогийг тооцсон, хөтөлбөр дэх мэргэжлийн хичээлүүд нь хоорондоо уялдаа холбоотой байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн харьцуулалтыг хийхдээ тухайн хөтөлбөрийн онцлог давуу талыг тодруулах, хөтөлбөрийн агуулгын хувьд харьцуулах тал дээр цаашдаа анхаарч ажиллах
- Төгсөлтийн дараах магистрын сургалтанд хамрагдаж буй гадаад, дотоодын оюутан, эрдэмтэн багш нараас цахим орчинд **www. <https://www.qualtrics.com/>** платформ ашиглан судалгаа авах, боловсруулах, хөтөлбөрийн шинэчлэлтэд тусгах

Зөвлөмж:

- УАУ магистрын хөтөлбөрт шинэ мэдлэг, шинэ үзэл баримтлал бий болгох, бусад сургуулийн хөтөлбөрөөс ялгарах байдлыг бий болгох

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөрийн зохион байгуулалт, хэрэгжилт

Магистрын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, эрх зүйн орчинг бүрдүүлж, магистрантын суралцахуй ба судалгааны ажлыг дэмждэг байна.

2.1 Элсэлт

Элсэгчид тавих шаардлага нь магистрын хөтөлбөрийн суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх боломжийг тооцсон, шударга, ил тод байна. Элсэгчийн мэргэжлийн болон судалгааны туршлага, ур чадвар, амжилтыг харгалзан тодорхой нөхцлөөр элсүүлэх боломжийг бүрдүүлэхээс гадна гадаад хэлний (TOFEL, IELTS) болон судалгааны чадавхыг үнэлэх олон улсын үнэлгээг тооцдог байна. Судалгааны сэдэв болон удирдагч багшийг сонгох, санхүүжилтийн хэлбэр, хэмжээг тогтоох журмууд нь тодорхой, ил тод байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын “Дээд боловсролын тухай” хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь заалт
- БШУ-ны сайдын 2014 оны 09 сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хавсралтуудаар батлагдсан “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”
- БСШУ-ны сайдын 2001 оны 113 дугаар тушаалаар батлагдсан гадаадын иргэдийг суралцуулах дүрэм, журам
- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01 захирлын 22-ны А/04 өдрийн тушаалаар батлагдсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- БНХАУ, Хөх хотын АУИС, БНХАУ. ӨМӨЗО.ӨМҮИС, Японы Токио Ариаке ИС-тай хамтран ажиллах гэрээ
- АШУҮИС-ийн гадаадын суралцагчдад зориулсан монгол хэл, соёлын хөтөлбөрийн танилцуулга
- Магистр, докторын гадаад оюутнуудад зориулсан элсэлтийн танилцуулга
- АШУҮИС-ийн магистрын элсэлтийн тушаалууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- УАУ-ны хөтөлбөрөөр магистрт суралцах суралцагчийг сонгох элсүүлэх ажиллагаа нь хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар зохицуулагддаг.
- Тухайн жилд элсүүлэн авах магистрантын тоог МАУОУС-аас тэнхмүүдийн ирүүлсэн саналд үндэслэн Эрдмийн сургуульд гарган өгдөг бөгөөд Эрдмийн сургууль нь элсэлтийн бүртгэлийн товыг зарлаж, шалгалтыг зохион байгуулдаг.

- Элсэлтийг хавар, намар 2 удаа зохион байгуулдаг нь суралцагсдын элсэн суралцах боломжийг нэмэгдүүлсэн төдийгүй багшийн ачааллыг тэнцвэржүүлэхэд эерэг нөлөө үзүүлдэг.
- 2020 оноос элсэлтийн шалгалтыг цахим хэлбэрээр авдаг болсон.
- Элсэлтийн шалгалтыг англи хэлний ерөнхий мэдлэг болон мэргэжлийн чиглэлээр зохион байгуулдаг ба уг 2 шалгалтын дунджаар оноогоор тооцдог болсон нь элсэгчдийн хувьд шалгалтанд тэнцэх боломжийг нь нэмэгдүүлдэг байна.
- БНХАУ, ӨМӨЗО-ы Тунляо хотын ӨМҮИС-иас ирсэн суурин төлөөлөгчийг байнгын орон тоон дээр ажиллуулж байгаа нь 2 сургуулийн хамтын ажиллагаа, магистр, докторын элсэлт, төгсөлтийн үйл ажиллагаанд ахиц гаргах, тэр нь гадаадаас элсэх элсэгчдийн тоо өссөн үр дүнгээр нотлогдож байна. Түүнчлэн БНХАУ, ӨМӨЗО-ы Анагаахын сургуулиудын 3+2 дипломыг бакалаврын боловсролын дипломд дүйцүүлэн тооцсон нь гадаад суралцагчдын магистрын сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлсэн байна.
- УАУ-ны чиглэлээр шинжлэх ухааны магистрын хөтөлбөрт элсэгчдийн тоо сүүлийн 5 жилээр тасралтгүй өсөж 2015 онтой харьцуулахад элсэлтийн тоо 2020 онд 60%-иар нэмэгдэж, ялангуяа тус хөтөлбөрт элсэн орж байгаа гадаад элсэгчдийн тоо тасралтгүй нэмэгдсээр байна. 2020 онд 6 гадаад суралцагч элссэн буюу нийт 26 гадаад суралцагч суралцаж байна.

2.2 Суралцахуйн ачаалал, багц цаг

Хөтөлбөрөөр суралцах магистрантын танхимд болон бие даан суралцах, судалгаа хийх ачаалал нь улирал бүрт жигд, зохистой хэрэгжиж хэт ихсэх буюу багасахаас сэргийлдэг байна. Магистрантын суралцах хугацаа хэвийн хэмжээнээс хэтрэхгүй байхад чиглэсэн арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01 захирлын 22-ны А/04 өдрийн тушаалаар батлагдсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Хичээлийн хуваарь
- Хичээлийн календарьчилсан төлөвлөгөө
- Магистрантын суралцах гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын сургалтын хичээлийн жил нь 16-аас доошгүй долоо хоног бүхий хаврын болон намрын гэсэн 2 улирлаас бүрдэх ба хаврын улирал нь 4-р сарын 1, намрын улирал нь 10-р сарын 1-нд тус тус эхэлдэг бөгөөд улирал бүр шалгалтын нэг долоо хоногтой байдаг.
- Магистрант нь элссэн улирлын эхний сардаа багтаан суралцах гэрээ байгуулж, сургалтын нэгдсэн хуанлид заасан хуваарийн дагууд хичээлээ судлаад улирал бүрийн төгсгөлд судалсан хичээлийн багц цаг, түүнд харгалзах үнэлгээг Эрдмийн сургуулиар хянуулж, баталгаажуулдаг.

- Хичээлийг 4 семестрт хуваан, ачаалал жигд байхаар тооцож төлөвлөсөн. Сургалтын төлөвлөгөөн дэх нийт 41 багц цагийн хичээлийг хичээлийн жилийн I улиралд 5 кр, II улиралд 14 кр, III улиралд 14 кр, IV улиралд 8 кредит байхаар оноосон нь ачаалал нь 1, 2 р курстээ жигд хувирагдсан гэж үзэхээр байна.
- Суурь боловсролын 11 багц цагийн хичээл, мэргэжлийн суурь хичээл 10 багц цаг, мэргэшүүлэх хичээл 6 багц цаг, бие даалт болон сонгон суралцах 6 багц цаг, судалгааны ажил диссертаци бичилт хамгаалалтын 8 багц цаг буюу ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн харьцаа нь 26.8%:24,4%:48.8% байна.
- Эрдмийн сургуульд гадаад оюутнуудад зориулсан Монгол хэлний төвийг АШУУИС-ийн захирлын 2020 оны 04-р сарын 14-ний А/80 тушаалаар байгуулж орон тооны багшийг бий болгож монгол хэлний хичээлийн 16 кредит бүхий хөтөлбөр боловсруулж сургалтыг явуулж эхэлсэн.
- Сургуулийн Эрдмийн зөвлөлийн төлөвлөгөөнд магистрант болон удирдагч багшийн тохирлсоноор хамгаалах товыг оруулж өгдөг болсон нь магистрантуудын хугацаандаа эрдмийн зэргээ хамгаалахад түлхэц болж өгсөн.

Анхаарах асуудал:

Зөвлөмж:

- Сургалтын хөтөлбөртөө өөрийн үнэлгээ тасралтгүй хийж сайжруулахад ажил олгогч төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай харилцан хамтарч ажиллаж, тэднээс гарсан саналыг тусган ажиллах

2.3 Багшлахуй ба суралцахуйн арга зүй

Багшлахуй ба суралцахуйн арга зүй нь суралцагч төвтэй арга барилд тулгуурласан, магистрантыг суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай суралцахад нь дэмждэг байна. Үүний зэрэгцээ судлаачийн болон мэргэжлийн ёс зүй, арга барилыг дээдлэн хөгжүүлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУУИС-ийн захирлын 2016 оны 01 захирлын 22-ны А/04 өдрийн тушаалаар батлагдсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам
- Удирдагч багшийн төлөвлөгөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- СБЗГ-ын дэргэд Багшийн хөгжлийн төв нь 2014 онд бий болж багш бүр судлаач байх, тасралтгүй суралцагч байх, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, багш бүр цол зэргээ ахиулсан байх гэсэн зарчмын дагуу сурган, заах арга зүй болон мэргэжлийн чиглэлийн тасралтгүй сургалт явуулж тус сургуулийн багш нар нь 100 хувь хамрагдсан нь нотлогдлоо.
- АШУУИС, МАУОУС-ийн магистрын хөтөлбөрт багшилж буй нийт багш нар нь БШУ-ны сайдын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралт

буюу “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 2.8 Багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлага, АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01-р сарын 22-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 2.3 Багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.

- Journal club-ийн үйл ажиллагаагаар дамжуулан эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйд сургах, судалгааны үр дүнг задлан шинжилж, зохих дүгнэлт өгөх чадварт сургах, магистрантын судалгааны ажлын үр дүн явцтай танилцах, арга зүйн зөвлөгөө өгөх, судлаачийн ёс зүй, диссертацид тавигдах шаардлага зэрэг судлаач эзэмших ёстой мэдлэг чадвар хандлагыг эзэмшүүлэх олон талт сургалтыг явуулж хэвшсэн.
- Магистрантуудын эрдэм шинжилгээний хурал, чуулганд оролцох, үр дүнгээ хэлэлцүүлэх, эрдмийн бүтээлээ хэвлүүлэх байдал нь тогтмолжсон, хамрагдалт өндөр хувьтай багаа нь нотлогдлоо.
- Суралцагчдын бие даан суралцах үйл ажиллагааг дэмждэг, эргэх холбоотой ажиллаж чаддаг. Сургууль дээр номын сан бүхий уншлагын өрөө, ур чадварын 3 танхим ажиллаж суралцагсад бие даан хичээллэх, суралцах нөхцлийг хангаж өгсөн.
- Цахим орчинд багш суралцагчдад HINARI системд нэвтрэх кодыг нээлттэй ашиглуулдаг ба ингэснээр 120 мэдээллийн сангаас Springer, Elsevier Science, McGraw Hill зэрэг шинжлэх ухааны 13000 сэтгүүл, 56000 цахим номыг унших боломжтой.
- Багш оюутнуудын дунд онлайн мэдээллийн сангийн ашиглалтыг нэмэгдүүлэх сургалтыг явуулдаг ба үүний үр дүнд онлайн мэдээллийн сангийн хандалтын тоо жил бүр өссөн статистик гарсан байна.
- АУТНС нь 2016 оноос эхлэн номын сангийн нээлттэй эх бүхий “KOHA Integrated Library System” программыг номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлэн хөгжүүлж эхэлсэн. Номын сангийн электрон каталогт нийт 35515 ном сурах бичиг, эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл, сэтгүүлийн өгүүлэл бүртгэн хайлт хийх боломжтой болсон. 2019 оны 4 дүгээр улиралд номын сангийн серверийн хүчин чадлыг нэмж хайлтын системийн хурдыг нэмэгдүүлсэн нь суралцагчдын сурах боломжид таатай нөлөө үзүүлсэн нь нотлогдлоо.
- Ковид халдварын нөхцөл байдлаас шалтгаалан магистрын хэлэлцүүлэг, хамгаалалтыг цахимаар хийлгэсэн. 2020 онд Zoom программаар 12 магистрын жинхэнэ хамгаалалтыг цахимаар хийсэн. Үүний 6 нь БНХАУ-ын Хөх хот, Тунляо, Хөлөнбуйр зэрэг газраас холбогдож магистрын жинхэнэ хамгаалалт хийсэн.

2.4 Судалгааны ажил

Магистрант болон удирдагчийн үйл ажиллагааг харилцан уялдаатай тодорхойлсон ил тод журмаар сургалтын болон ганцаарчилсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу магистрантын судалгааны ажлын гүйцэтгэлийг хянан идэвхжүүлдэг байна. Удирдагч багш нар нь судалгааны ажлыг удирдах ур чадвараа байнга хөгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлдэг байна

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01 захирлын 22-ны А/04 өдрийн тушаалаар батлагдсан Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам

- АШУУИС-ийн МАУОУС-ийн Эрдмийн чуулганы бүтээлүүд
- Дорно дахины анагаах ухаан, Нэгтгэмэл анагаах ухааны монголын сэтгүүлийн дугаарууд
- Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүлийн дугаарууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУУИС-ийн Төсгөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журмын 3.4 хэсэгт удирдагч багш, зөвлөх багшийн гүйцэтгэх үүрэг, тодорхойлолт, 3.5 хэсэгт заасан удирдагч багш, зөвлөх багшийн эрх, үүргийг тодорхой зааж өгсөн бөгөөд энэхүү журмаар зохицуулагддаг.
- Судалгааны ажлын сэдэв удирдагчийг сонгох асуудал нь мэргэжлийн тэнхимийн хүрээнд нээлттэй явагдаж, тэнхимийн хурлаар батлагддаг.
- Багш бүр жилийн ажлын төлөвлөгөөнд удирдаж байгаа магистрын ажлыг хугацаанд нь хийлгэх, хамгаалуулахаар тусгадаг бөгөөд багшийн үнэлгээний гол хэсэг нь эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл байдаг тул багш бүр магистрантуудтай тулж ажиллаж удирдагчийн үүргийг гүйцэтгэж чаддаг.
- Багш нарын мэдлэг, ур чадварыг аттестатчлалын дүнгээр тооцож тухайн багшийн хөдөлмөрийн гэрээг сунгах эсэх, албан тушаалын зэрэглэл ахих болон буурах эсэхийг шийдвэрлэдэг журамтай. Үүний дагууд багшийн эрдэм шинжилгээний ажил хийж магистрант докторант удирдах, төсөл хөтөлбөрт хамрагдах хувь хангалттай гэж үзэхээр байна.
- Багшийн ажлын гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилсан багш нарыг урамшуулан ажилладаг тогтолцоо бүрдсэн. Төсгөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, АШУУИС-ийн захирлын 2016 оны 06-р сарын 10 ны өдрийн А/72, 2017 оны 09-р сарын 29ны А/125 , захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2019 оны 12 сарын 27-ны А/415 тоот тушаалын дагуу магистрын сургалтын үндсэн ачаалалд мөрдөх цагийн тооцооллыг үндэслэн магистрын удирдагч зөвлөх, шүүмжлэгч багш нарын гүйцэтгэлийг удирдагч багшид 144 оноо, зөвлөх багш 48 оноо, шүүмжлэгч багшид 20 оноогоор тооцож цалин урамшууллыг олгодог. 2019 онд МАУОУС-ийн 7 багшид тухайн хичээлийн жилд магистрт заасан цагийг тооцон 2.232.000 төгрөг олгогдсон байна.
- Багш нарын эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг оноогоор үнэлэх (төсөлд ажиллах, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл хэвлүүлэх, журнал клуб зохион байгуулах, оюуны өмчийн бүтээлийн гэрчилгээ авах, мэргэжлийн ном сурах бичиг бичих, редактор хийх, эрдмийн зэрэг хамгаалах, эрдмийн цол ахих, магистрын эрдэм шинжилгээний ажил удирдах, эрдэмтдийн зөвлөл, ёс зүйн хороонд гишүүнээр ажиллах) журам хэрэгждэг.
- Суралцагчдын сурган заах арга зүйн болон эмнэлзүйн чадварыг дээшлүүлэх зоригор багшийн удирдлага дор 2 багц цагийн хичээл заалгах, эмнэлэг сувиллын үйл ажиллагаанд оролцох татан оролцуулах ажлыг хэвшүүлсэн.
- Магистрын удирдагч, зөвлөх багш нарт ажлын гүйцэтгэлийг онооны системээр дүгнэж

тохирсон урамшуулал олгодог. 7 багшид 2 сая гаруй төгрөгийн урамшуулал олгосон байна.

Анхаарах асуудал:

- Суралцагчид элсэн орсоны дараа аль нэг тэнхимд харъяалагдаж багшаа сонгох, сэдэв сонгох үйл ажиллагаа явагддаг ба энэ нь баримжаа багатай, хугацаа алдахад нөлөөлдөг тул элсэхээс өмнө судалгааны ажлын чиглэл, зарим нэг сэдэв зарлагддаг бол суралцагчийн зорилгод нийцэхээр байна.

Зөвлөмж:

- Судалгааны ажлын сэдэв, чиглэлийг элсэлтээс өмнө зарладаг байдлыг бий болгох

2.5 Бүтээлч ажил

Магистрант нь шинжлэх ухааны арга хэмжээ, бага хурал, мэргэжлийн хэлэлцүүлэг зэрэг шинжлэх ухааны болон мэргэжлийн арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцох, судалгааны бүтээлээ хэвлүүлдэг байна. Магистрантын бүтээлч ажлыг дэмжин урамшуулах, үнэлэх, баталгаажуулах тогтолцоотой байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн МАУОУС-ийн Эрдмийн чуулганы бүтээлүүд,
- Дорно дахины анагаах ухаан, Нэгтгэмэл анагаах ухааны монголын сэтгүүлийн дугаарууд
- Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүлийн дугаарууд
- Магистрантуудын судалгааны ажил, авсан шагнал урамшуулал
- Магистрантуудын төсөл хөтөлбөрт хамрагдсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУС-ийн багш нар ЭМЯ, БСШУЯ, ШУТС зэрэг олон байгууллагатай хамтран ажиллаж суурь судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацын чиглэлээр 8 төсөл, гэрээт ажил хэрэгжүүлж түүндээ суралцагчдаа татан оролцуулж судалгааны арга зүй, удирдамжаар хангаж цаашлаад хувь суралцагчаас гарах судалгааны зардалд дэмжлэг болж байгаа нь том амжилт гэж харагдаж байна. (“Monberry” олон үйлдэлт шинэ био бэлдмэлийн технологи”, “МАУ-д өргөн хэрэглэгддэг зарим эм бэлдмэлийн түүхий эдийн нөөцийг нэмэгдүүлж, үйлдвэрлэлд ашиглах дэвшилтэт технологи боловсруулах”, “Байгалийн гаралтай эмийн ургамлын урт наслуулах, адаптоген үйлдэлтэй биологийн идэвхт бодис, уламжлалт шинэ эм, бэлдмэлийн судалгаа”, “Уламжлалт жор найралтад суурилсан томуугийн эсрэг “Дэмон”сироп, цөсний туулга, “Бербера”гель болон “Шимт” тосыг туршин зохион бүтээх инновацын төсөл, Элэгний хавдрыг эмчлэх Шинэ эмийн судалгаа, Өвсөн гурван халуун эмийн судалгаа ЭМЯ-ны захиалгат төсөл, Жоншноос ясны сийрэгжилтийн биологийн идэвхт бүтээгдэхүүн гаргаж авах судалгаа)
- 2016-2020 оны хугацаанд 13 магистрант төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдан АУ-ны магистрын зэргээ амжилттай хамгаалсан байна.

- Магистрантууд судалгааны ажлын үр дүнг жил бүр уламжлал болгон зохиогддог АШУҮИС-ийн Эрдмийн чуулган, Хүрэлтогоот болон бусад эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж амжилттай оролцож хэвшсэн.
- Магистрантуудыг сургууль дээр явагдаж буй сургалт, эрдэм шинжилгээ, эмнэл зүйн үйл ажиллагаа, олон нийтийн ажилд татан оролцуулдаг. Тухайлбал Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын иргэдэд урьдчилан сэргийлэх үзлэгийг багш нар нь гадаад, дотоодын магистрантуудын хамт хийж гүйцэтгэсэн нь суралцагчдын эмнэл зүйн үр чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг болсон нь суралцагч төгсөгчидтэй хийсэн уулзалтаас нотлогдлоо.

Анхаарах асуудал:

- УАУ-ны чиглэлээр шинжлэх ухааны магистрын хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан элсэгчдийн хэдэн хувь нь тэнцсэн эсэх талаар судалгаа боловсруулалтын дүн байхгүй, үүнд дүгнэлт хийх боломжгүй байгаа нь элсэлтийн шалгалтыг Эрдмийн сургууль дангаар зохион байгуулж авдаг нь учир дутагдалтай байгааг харуулж байна.
- Магистрантыг дотоод, гадаадын төсөл дээр ажиллуулж, арга зүйгээр хангаж ажиллаж буй удирдагч багш нарт дэмжлэг үзүүлж урамшуулах

Зөвлөмж:

- Сургуулийн зүгээс суралцагсдад хөнгөлөлт үзүүлэх, судалгаа шинжилгээний ажлын зардалд сургалтын төлбөрөөс тодорхой хувийг эргүүлэн зарцуулах боломжийг бий болгох

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Магистрантын суралцахуйн үнэлгээ, хөгжил

Хөтөлбөрөөр суралцагч нь суралцахуйн зорилтот үр дүнд амжилттай хүрэхэд чиглэсэн ил тод, шударга үнэлгээний системтэй байх ба амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь зөвлөн тусалдаг байна.

3.1 Суралцахуйн үнэлгээ, шалгалт

Хөтөлбөрийн явцад үнэлгээний олон төрөл хэлбэрийг ашиглан суралцагчийн суралцахуйн зорилтот үр дүн (мэдлэг, чадвар, дадал)-гийн гүйцэтгэлийг үнэлэх тогтолцоотой байна. Үнэлгээний журам, шалгуур нь сургалт, судалгаа, соён гэгээрүүлэх ажлыг бүхэлд нь хамарсан байх ба суралцагчийн амжилтыг шударга ил тод үнэлж, сайжруулдаг

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын БСШУ-ны сайдын 2007 оны 187 тоот тушаалын “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, 2010 оны 492 дугаар тушаалаар орсон нэмэлт өөрчлөлт тусгасан/
- АШУҮИС-ийн “Суралцагчийг үнэлэх журам” 2015 оны 12 сарын 15-ны өдрийн А/144 хавсралт 1-ээр СБЗГ-ын баталсан “Суралцагчийг үнэлэх журам”.
- АШУҮИС-ийн 2016 оны 1 сарын 22-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

- АШУҮИС-ийн 2020 оны 6 сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийг үнэлэхдээ АШУҮИС-ийн захирлын 2015 оны 12 сарын 15-ны өдрийн А/144 тушаалаар батлагдсан Суралцагчийг үнэлэх журмыг баримтлан явцын болон төгсгөлийн үнэлгээг хийдэг.
- Уламжлалт анагаахын магистрын сургалтанд суралцагчдын мэдлэг, ур чадвар, цогц чадамжийг үнэлэх шалгалтыг дараах арга хэлбэрүүдээр авч үнэлдэг. Үүнд аман шалгалт, эссэ бичих бичгийн шалгалт, сорил, эмнэлзүйн тохиолдолд суурилсан шалгалтууд хамаардаг.
- Оюутны сурлагын амжилт, дүнд судалгаа хийхэд жил бүр ахисан үзүүлэлт гарсан байна.

Анхаарах асуудал:

- Сургалтын үйл ажиллагаа, суралцагчийг үнэлэх ажиллагаа цахимд шилжсэнтэй холбоотой удирдлага мэдээллийн системийн аюулгүй байдалд анхаарч ажиллах

3.2 Суралцагчийн хөгжил, суралцахуйн хүрсэн үр дүнг хүлээн зөвшөөрөх

Хөтөлбөрөөс гадуур суралцагчийн бие даан эзэмшсэн болон өөр сургууль, хөтөлбөрөөс суралцсан суралцахуйн үр дүнг хүлээн зөвшөөрч, багц цагийг дүйцүүлэн тооцдог байна. Түүнчлэн суралцагчийн mobility-г дэмжсэн /багц цагийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, багц цагаас чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нийцүүлдэг байна

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн 2020 оны 6-р сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Дотооддоо өөр сургуулиас шилжин ирдэг тохиолдол гараагүй.
- БНХАУ, ӨМӨЗО-ы Анагаахын сургуулиудын 3+2 дипломыг дүйцүүлэн тооцдог болсон.
- Эрдмийн сургууль дээр хятад хэлтэй гадаад суралцагч хариуцсан мэргэжилтэн ажиллуулдаг болсон.
- Визаны асуудалтай нэг суралцагчийн асуудлыг шийдвэрлэж цахимаар хамгаалалтыг хийлгэсэн.

3.3 Магистрантыг дэмжих, зөвлөх үйлчилгээ

Суралцагчдыг амжилттай суралцах, хөгжиж төлөвшихөд нь дэмжих, зөвлөх үйлчилгээг

системтэйгээр үзүүлдэг байна. Дэмжих, зөвлөх үйлчилгээ нь суралцагч /гадаад, шилжин ирсэн, ажил эрхэлдэг ба эрхэлдэггүй, боловсролын тусгай хэрэгцээтэй гэх мэт/-ийн хэрэгцээ, шаардлагаас үүдэх суралцахуйн орчин, нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдэхэд тусалж, сэтгэл ханамжийг дээшлүүлдэг байна. Магистрантын санал хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үйл явцыг тэдэнд нээлттэй мэдээлж, албан ёсны гомдлыг бүртгэж баримтжуулан, шийдвэрлэдэг байна..

Илрэл нотолгоо:

- Journal club-ийн үйл ажиллагааны тайлан, протоколууд, зурагт альбом
- АШУҮИС-ийн захирлын 2020 оны 4 сарын 14-ны А/78 тоот тушаал, Сургалтын төв байгуулах тухай
- “Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл”, УБ, хот 2017он
- “Сургалтын бодлого зохицуулалттай холбоотой дүрэм журмын эмхэтгэл” УБ хот 2018 он
- АШУҮИС-ийн “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУС-ийн тэнхим бүр өөрсдийн харьяанд суралцдаг судлаачдаа Journal club-ийн үйл ажиллагаанд хамруулдаг. Жил бүр дунджаар 10 удаагийн журнал клуб зохион байгуулагдаж тухай бүрт 20 орчим магистрант оролцдог.
- Journal club-ийн үйл ажиллагаагаар судлаачид олон улсын түвшний судалгаа, шинжлэх ухааны сүүлийн үеийн нээлт, шинэ мэдээлэл солилцон, өөрсдийн судалгааны ажлаа бусад судлаачдад танилцуулж, мэдлэгээ хуваалцах, багш нарын зүгээс судлаачийн ёс зүй, диссертацид тавигдах шаардлага зэрэг судлаач эзэмших ёстой мэдлэг чадвар, хандлагыг багтаасан олон талт сургалт явуулж туршлага солилцдог.
- АШУҮИС-ийн урлаг, спортын наадам болон Улсын болон хувийн хэвшлийн анагаахын сургуулиудын уралдаан, тэмцээнд магистрантуудыг оролцуулдаг.
- Сургуулийг үндэслэн байгуулагч профессор Н.Төмөрбаатарын нэрэмжит “Монгол Анагаах Ухаан 21-р зуунд” Улсын эрдэм шинжилгээний хурлыг 2015 оноос жил бүр уламжлал болгон тогтмол зохион байгуулж магистрантуудыг оролцуулж хэвшсэн.
- Багш судлаачдын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулснаар багш шавийн хооронд туршлага, мэдлэг, шинэ мэдээллийг солилох, эргэх холбоо сайжрах үр нөлөөтэй.
- Магистрантыг төлөвшүүлэх, нийгмийн идэвхийг сайжруулах зорилгоор УАУТХ, Эрхэс сувиллын хаврын тохижилт үйлчилгээний ажилд татан оролцуулдаг.
- Магистрын диплом олгох, гардуулах ёслын үйл ажиллагаа (хичээлийн жилийн намар болон хаврын улиралд 06 сар, 12 сар)-г жилд 2 удаа зохион байгуулдаг.
- Жилд нэг удаа бүх багш магистрын нэгдсэн хурал, сургуулийн шинэ жилийн нэгдсэн үйл ажиллагааг сургуулийн хэмжээнд зохион байгуулдаг.
- Төгсөлтийн сургалтын талаар суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, ажил олгогчийн судалгаа, захиалагч талын хэрэгцээ тодорхойлох үйл ажиллагааны талаарх

судалгааг хийж эхэлсэн.

Анхаарах асуудал:

- Төгсөлтийн сургалтын талаар суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, ажил олгогчийн судалгаа, захиалагч талын хэрэгцээ тодорхойлох судалгааг тогтмолжуулах, тодорхой давтамжтай авах тал дээр анхаарах

Зөвлөмж:

- Төгсөлтийн сургалтын талаар суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа, ажил олгогчийн судалгаа, захиалагч талын хэрэгцээ тодорхойлох судалгааг тогтмолжуулах

3.4 Судалгааны санхүүжилт

Сургуулийн судалгааны бодлого, хөтөлбөрийн зорилгод нийцүүлэн, магистрантын судалгааны ажлыг санхүүжүүлэх, санхүүжилтийг хянах, гүйцэтгэлийг үнэлэх ил тод бодлого, журмыг хэрэгжүүлж, жил бүр ил тод тайлагнадаг байна.

Илрэл нотолгоо:

- Төслийн удирдагч: Д.Цэнд-Аюуш. Уламжлалт жор найралтад суурилсан томуугийн эсрэг “Дэмон” сироп, цөсний туулга, “Бербера” гель болон “Шимт” тосыг туршин зохион бүтээх инновацын төслийн эцсийн тайлан. 2018 он
- Төслийн удирдагч: Б.Цэрэнцоо. “Байгалийн гаралтай эмийн ургамлын урт наслуулах, адаптоген үйлдэлтэй биологийн идэвхт бодис, уламжлалт шинэ эм, бэлдмэлийн судалгаа” төслийн эцсийн тайлан. 2019 он
- Төслийн удирдагч: Ж.Байгалмаа. “Monberry” олон үйлдэлт шинэ био-бэлдмэлийн технологийн төслийн эцсийн тайлан. 2018 он
- Багш нарын сургалтад хамрагдсаныг нотлох сертификат, батламжууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС Эрдмийн сургуулиас багш нарын мэдлэгээ дээшлүүлэх, чадавхжуулах, хувь хүний болон эрдэм шинжилгээ судалгаа, анагаах ухааны сурганы чиглэлийн урт богино хэмжээний сургалтуудыг тасралтгүй явуулдаг бөгөөд МАУОУС-ийн багш нар 100% хамрагдсан нь тайлан болон нотлох баримтаас харагдлаа.
- Сургуулийн багш нар өөрсдийн нөөц боломж чадамж дээр тулгуурлан ЭМЯ, БСШУЯ, ШУТС зэрэг олон байгууллагатай хамтран ажиллаж суурь судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацын чиглэлээр 8 төсөл, гэрээт ажил хэрэгжүүлж түүндээ суралцагчдаа татан оролцуулж судалгааны арга зүй, удирдамжаар хангаж цаашлаад хувь суралцагчаас гарах судалгааны зардалд дэмжлэг болж байгаа нь том амжилт гэж харагдаж байна.
- Гадаад болон дотоодын 8 төсөл хөтөлбөр хэрэгжүүлж энэхүү ажлын хүрээнд 13 суралцагч магистрын зэргээ хамгаалсан.
- Гүйцэтгэж буй төсөлт ажлын тайланг төсөл бүрээр нэг бүрчлэн гаргаж төслийн үн дүнг хүлээлгэн өгсөн байв.

Анхаарах асуудал:

- АШУҮИС Эрдмийн сургуулиас хөтөлбөр хэрэгжүүлж буй нэгж тэнхим сургуульд тодорхой хэмжээний урамшуулал олгоно гэж журамд заасан боловч бодит байдал дээр хэрэгжээгүй, журмын хэрэгжилтэнд анхаарч ажиллах

3.5 Тэтгэлэг, тэтгэмж

Магистрантын сургалтыг санхүүжүүлэх эх үүсвэр, тэтгэлэг, тэтгэмж олгох нөхцөл, болзлыг тодорхой заасан дүрэм журмыг хэрэгжүүлж, үр дүнг жил бүр хянан үнэлдэг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01-р сарын 22-ны өдрийн “АШУҮИС-ийн “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”,
- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 10 сарын 18-ны захирлын Сургалттай холбоотой үйл ажиллагааны үнэ тариф батлах тухай А/109 тушаалын 2 дугаар хавсралт “Магистр, докторын сургалттай холбоотой урамшуулал”
- Магистрантуудын судалгааны ажил, авсан шагнал урамшуулал
- Магистрантуудын төсөл хөтөлбөрт хамрагдсан тайлан

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрантууд судалгааны ажлын үр дүнг Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлж БСШУ-ы сайдын нэрэмжит тэтгэлэг авсан, байр эзлэн шагнал урамшуулал авсан амжилт үзүүлсэн нь судалгааны ажлын үр дүн үнэ цэнийг илэрхийлж байна.
- Магистрантууд нь удирдагч багш нарын хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрт хамрагдаж дам байдлаар судалгааны ажлын зардлаас хөнгөлөлт чөлөөлт эдэлдэг.

Анхаарах асуудал:

- АШУҮИС-ийн захирлын 2016 оны 01-р сарын 22-ны өдрийн “АШУҮИС-ийн “Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-д заасны дагуу магистрантуудад тэтгэлэг, тэтгэмж олгодог гэж тайлагнасан боловч нотлох баримтаар нотлогдсонгүй.

Шаардлага:

- Суралцагсдад сургалтын төлбөрөөс тодорхой хувийг тэтгэлэг, санхүүгийн дэмжлэг байдлаар эргүүлэн олгож судалгааны зардалд хэрэглэх боломжийг бий болгох, төгсөлтийн сургалтын журамд тусгайлсан заалт оруулах

3.6 Судалгааны баг, хамтын ажиллагаа

Хөтөлбөрийн түвшинд үндэсний болон олон улсын, төрийн болон хувийн байгууллага, дээд боловсролын сургалтын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх гэрээтэй, дотоод болон гаднын судалгааны нэгж болон байгууллагуудтай холбоо тогтоож, түншилдэг байна. Багш, магистрантууд судалгааны багт оролцдог байна.

Илрэл нотолгоо:

- Токио ариакэ эрүүл мэндийн сургуультай хийсэн хамтын ажиллагааны гэрээ 2015.09.08. /жил бүр автоматаар сунгагдах гэрээ/

- ӨМӨЗО-ны Өвөр Монголын Үндэстнүүдийн Их Сургууль "Inner Mongolia University of Nationalities" хамтын ажиллагааны гэрээ
- Тянжин хотын Уламжлалт Анагаахын Их Сургууль хамтын ажиллагааны гэрээ
- ӨМӨЗО-ны Алашаа аймгийн Монгол эмнэлгийн хороо "Hospital of Mongolian Medicine, Alxa League Inner Mongolia" хамтын ажиллагааны гэрээ
- Ляо Нинг мужийн Монгол эмнэлэг "Mongolian Medical Hospital of Lianing Province, People's Republic of China" хамтран ажиллах гэрээ
- ӨМӨЗО-ны Бугат хотын Монгол-Хятад эмнэлгийн хороо "Mongolian-Chinese Medical Hospital in Bugat Province, People's Republic of China" хамтран ажиллах гэрээ
- Шилийн голын Монгол эмнэлэг " Hospital of Mongolian Medicine, Xilin Gol province"
- ӨМӨЗО-ны Хөх хотын Монгол- Хятад эмнэлэг "Inner Mongolia, Mongolian Chinese Hospital" хамтран ажиллах гэрээ
- Монгол- Хятад эмнэлгийн хороо "Mongolian-Chinese Medical Hospital" хамтран ажиллах гэрээ
- 2015 онд БНХАУ-ын ӨМҮИС (Тунляо)-ийн их сургуультай хамтран ажиллах гэрээ
- АШУҮИС, Солонгосын Уламжлалт Анагаах ухааны төвтэй (KIOM- Korean Institute of Oriental Medicine) хамтран ажиллах гэрээ
- БНСУ-ын Кункее Их Сургуультай хамтран ажиллах гэрээ
- ӨМӨЗО-ны Хөх хотын ОУ-ын Монгол эмнэлгийн хороотой хамтран ажиллах гэрээ
- ӨМӨЗО-ны Хөх хотын АУИС-тай хамтран ажиллах гэрээ

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС нь 8 орны 12 сургууль, судалгааны төвтэй хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж ирсэн ба МАУОУСургууль нь БНХАУ,ӨМӨЗО-ы Тунляогийн Их Сургууль, Хөх хотын АУИС, ОУ-ын эмнэлгийн хороо, БНСУ-ын Кункее Их сургууль, Японы Токио Ариаке Их Сургуультай суралцагч солилцох, хамтарсан хөтөлбөр төсөл хэрэгжүүлэх хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна.
- Сургуулийн эрхлэн гаргадаг “Нэгтгэмэл анагаах ухаан” сэтгүүл нь Ази номхон далайн сэтгүүлүүдийн холбооны гишүүнчлэлд /WPRIM/ бүртгүүлсэн.
- Японы Токио Ариаке Их Сургуультай хамтран жүдо бариа засал, зүү төөнө заслын чиглэлээр оюутан суралцагч солилцох, хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлж байгаа бөгөөд 2019 онд Уламжлалт заслын тэнхимийн багш АУ-ны магистр Масатоши Нишикидо нь сургууль хоорондын хамтын ажиллагааны хүрээнд магистрын зэрэг хамгаалсан.
- 2019 онд уг хамтын ажиллагааны гэрээнд өөрчлөлт оруулж, Уламжлалт засалч мэргэжлээр төгссөн төгсөгчдөөс жилд 1-2 магистрантыг сургалтын төлбөрөөс чөлөөлж, Японд магистрт суралцуулах болсон.
- 2020-2021 оны хичээлийн жилд Уламжлалт бариа заслын тэнхимийг шинээр бий болгосон нь магистрын хөтөлбөр хэрэгжих, бариа заслыг шинжлэх ухааны аргаар хөгжүүлэх, нотлох судалгааны чиглэл хөгжихөд нэг алхам дээшилсэн үйл ажиллагаа болжээ.

3.7 Магистрын ажил хамгаалалт

Магистрын ажил хамгаалах зөвшөөрөл олгох (шинэ мэдлэгийг бий болгох, үр дүнг ашиглах, багшлахуйн үнэлгээ, шилжилт хөдөлгөөн гэх мэт) тодорхой шалгуурууд нь

магистрант, удирдагч нарт ойлгомжтой байна. Магистрын ажил хамгаалалтыг зохион байгуулах дүрэм (хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, гишүүдийн чиг үүрэг, хурлын дэг, танилцуулга хийх г.м.) магистрант, удирдагч нарт тодорхой, шударга, ил тод байдлаар хэрэгждэг байна.

Илрэл нотолгоо:

- Монгол Улсын БШУ-ны сайдын 2007 оны 187 тоот тушаалын “Магистр, докторын сургалт эрхлэхэд баримтлах нийтлэг журам”, /2010 оны 492 дугаар тушаалаар орсон нэмэлт өөрчлөлт тусгасан/
- АШУҮИС-ийн Суралцагчийг үнэлэх журам 2015 оны 12 сарын 15-ний өдрийн А\144 хавсралт 1-ээр СБЗГ-ын баталсан “Суралцагчийг үнэлэх журам”
- АШУҮИС-ийн 2016 оны 1 сарын 22-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУС-ийн Уламжлалт анагаах ухаан магистрын хөтөлбөрөөр эрдмийн зэргийн хамгаалалтын үйл ажиллагаа нь “АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар зохицуулагддаг. Энэхүү журмыг шинэчлэхээр санал оруулсан. Тухайлбал хамгаалалтын явцын хурлуудын тоог цөөлж 8 шат дамжлагыг 6 болгож бууруулах санал өгсөн нь магистрант суралцагчдын эрх ашигт нийцсэн өөрчлөлт болж чадахаар байна.
- “АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-ыг баримтлан төгсөлтийн сургалтын магистрын ажил хамгаалалтанд тэнхим, эрдмийн зөвлөл, нарийн бичгийн дарга байнга хяналт тавьдаг ба бүрэлдэхүүн сургуулиуд дотроо МАУОУС-ийн магистрын хөтөлбөрт элсэн суралцагсад төгсөлтийн хувь хамгийн өндөр байгаа нь багш суралцагч сургуулийн хамтын ажиллагаа нягт, сайн байгаагийн нэг шалгуур гэж харагдаж байна.

3.8 Төгсөлтийн баримт бичиг

Төгсөгчид суралцсан хөтөлбөрийн хичээл тус бүрээр мэдлэг, ур чадвар, дадлын түвшинг жагсаасан хавсралт (англи хэл дээр) бүхий диплом, баримт бичиг олгох үйл явцыг холбогдох журмын хүрээнд хэрэгжүүлдэг байна. Төгсөгчид олгох баримт бичгүүд нь тухайн оюутны чадамжийн тухай мэдээлэл болон хөтөлбөрийн тодорхойлолт, суралцахуйн үр дүн, агуулга, түвшин түүнчлэн боловсрол, мэргэшлийн зэрэгтэй холбоотой мэдээллүүдийг багтаасан байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн 2016 оны 1 сарын 22-ны өдрийн А/04 тоот тушаалаар батлагдсан “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”
- АШУҮИС-ийн 2020 оны 6 сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- АШУҮИС-ийн захирлын 2020 оны 6 сарын 23-ны өдрийн А/156 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “АШУҮИС-ийн төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”-аар төгсөлтийн үйл ажиллагааг зохицуулагддаг.
- Диплом олгох үйл ажиллагааг БШУ-ны сайдын тушаалаар батлагдсан журмын дагуу зохицуулдаг.
- Диплом гардуулах ёслолыг жилд 2 удаа (12 сард, 6 сард) зохион байгуулж байна.

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Багшлах бүрэлдэхүүн

Магистрын хөтөлбөрийн онцлогоос хамааран шинжлэх ухааны салбар ба суралцагчийн тоонд дүйцэх, хангалттай хүрэлцээтэй багшлах бүрэлдэхүүнтэй байна.

4.1 Багшийн нөөц

Тухайн хөтөлбөрийн мэргэжлийн чиглэл, боловсролын зэргийн түвшинд тохирсон боловсролын зэрэг, эрдмийн цолтой, багшлах өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багш, судлаачийн нөөцтэй байна. Багш, докторантын тооны харьцааг зохистой тогтоож, мөрддөг байна. Хөтөлбөрийн чанарыг сайжруулах зорилгоор үндэсний болон олон улсын тэргүүлэх судлаач, эрдэмтдийг хөтөлбөрт урьж ажиллуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- БШУ-ны сайдын 2014 оны 09-р сарын 12-ны өдрийн А/370 тоот тушаалын хоёрдугаар хавсралт буюу “Магистр, докторын сургалт эрхлэх нийтлэг журам”-ын 2.8
- АШУҮИС-ын Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам, 2020/06/23 А/156 тоот тушаалд тусгасан багшлах бүрэлдэхүүнд тавих шаардлага
- АШУҮИС-ын дүрэм, 2017/11/30 005 тоот тогтоол
- АШУҮИС-ыг шинэчлэх, хөгжүүлэх, стратеги төлөвлөгөө 2015-2024
- АШУҮИС-ын багшийн үйл ажиллагааг зохицуулах журам 2016/11/09 А/118 тоот тушаал
- АШУҮИС-ын захирлын 2020 оны бүтцэд өөрчлөлт оруулах тухай А190 тушаал
- АШУҮИС-ын захирлын 2020 оны Ажлаас чөлөөлж ажилд авах тухай Б348 тушаал
- АШУҮИС-ын захирлын багшийн орон тоо батлах тухай 2019/10/07 А/321
- Дээд боловсролын тухай хууль 13 дугаар зүйл багшийн тухай 13.1-13.6
- Багшийн алтан дүрэм
- Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримт хавтаст хийсэн 6 тэнхмийн 37 багшийн танилцуулга болон мэргэжлийн дипломын хуулбар, хуудас 1-40

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн нөөцийг АШУҮИС-ын дүрэм журмуудад үндэслэн боловсруулсан байна.

- Багшийн сонгох шалгаруулалтыг үе шаттайгаар дүрэм журмын дагуу зохион байгуулдаг
- Үндсэн багшийн тоо 24 хөтөлбөр хэрэгжүүлэгч 17 багш
- Гэрээт багшийн тоо 4
- Зочин багш 8
- Хөтөлбөр хэрэгжүүлэгч багш нарын эрдмийн цол зэргийн хувьд академич 6%, ШУ-ны доктор 12% доктор 82% эзэлж байна.
- Багш: магистрын харьцаа 1:14 -1: 15 байна

Анхаарах асуудал:

- Уламжлалт Анагаах ухааны сургуулийн багш сонгон шалгаруулах нэмэлт шалгуур үзүүлэлт бий болгоход анхаарах

Зөвлөмж:

- Уламжлалт Анагаах ухааны сургуулийн багш сонгон шалгаруулах нэмэлт шалгуур боловсруулж сонгон шалгаруулалтын журамд тусгах

4.2 Багшлахуйн үнэлгээ

Багшлахуйн үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, үнэлгээний үйл явцыг тодорхой журамлан, хөтөлбөрийн зорилго, зорилтуудад нийцүүлэн багшийн ур чадварыг шударга, бодитой, системтэй, тогтмол үнэлж, үнэлгээний үр дүнг цаг тухайд нь танилцуулдаг байна. Чадахуйд суурилсан үнэлгээний тогтолцоо нь багшийн байнгын хөгжлийг дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- “АШУҮИС-ийн дүрэм” (АШУҮИС-ийн Удирдах Зөвлөлийн 2017-11-30 005 тоот тогтоол)
- “АШУҮИС-ийн дүрэм” (АШУҮИС-ийн Удирдах Зөвлөлийн 2020-04-03 002 тоот тогтоол)
- АШУҮИС-ийг шинэчлэх, хөгжүүлэх стратеги төлөвлөгөө /2015-2024/
- АШУҮИС-ийн “Багшийн үйл ажиллагааг зохицуулах журам” (АШУҮИС-ийн захирлын 2016-11-09 А/118 тоот тушаал)
- “Төгсөлтийн дараах сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам” (АШУҮИС-ийн захирлын 2019-05-27 А/187 тоот тушаал)
- [АШУҮИС-ийн “Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам”](#) (АШУҮИС-ийн захирлын 2016-06-10 А/72 тоот тушаал)
- [“АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”](#) (АШУҮИС-ийн захирлын 2016-01-22 А/04 тоот тушаал)
- “АШУҮИС-ийн Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам” (АШУҮИС-ийн захирлын 2019-12-27 А/415 тоот тушаал)
- [“АШУҮИС-ийн Төгсөлтийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах журам”](#) (АШУҮИС-ийн захирлын 2020-06-23 А/156 тоот тушаал)
- Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний дүнгийн хуудас /2016-2020/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- МАУОУС-ийн магистрын хөтөлбөрт орж буй багш нарын ажлын гүйцэтгэлийг албан

тушаалын зэрэглэлээс хамааран ялгавартай байдлаар, сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа гэсэн 3 чиглэлээр буюу нийлбэр оноог 1600 байхаар үнэлдэг.

- Багшийн гүйцэтгэх судалгаа эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаа, сургалтын харьцаанаас хамаарч ажлын гүйцэтгэлийг үнэлэх журамд багш-мэргэжилтэн, багш-судлаач, багш –багшийн орон тоог бий болгосон байна.
- Багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурт хөндлөнгийн үнэлгээ хийгддэг
- 3-5 жил тутам багшийн ажлыг үнэлэх загварын дагуу өөрийн үнэлгээний тайлан бичиж нотлох баримтаар баталгаажуулж СБЗГ-ын харьяа Багшийн хөгжлийн зөвлөлөөр үнэлүүлдэг.
- АШУҮИС-ийн профессор, дэд профессор, ахлах багш, багш дадлагажигч багш нарын сургалт эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар гүйцэтгэх ачааллыг тооцох жишиг үзүүлэлтийг баримтладаг.
- Хөдөлмөрийн гэрээгээр мэргэжлийн ачааллыг хөнгөлөх, бууруулах талаар тусгасан байдаг. Тухайлбал Хөдөлмөрийн гэрээнд ажил хавсран гүйцэтгэж байгаа бол 5-50 хүртэл хэмжээгээр хортой нөхцөлд ажиллаж байгаа бол мэргэжлийн үйл ажиллагааны ачааллыг 25 хүртэл хувиар бууруулдаг байна.
- Багшийн ажлын гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилсан багш нарын урамшууллын тогтолцоо бүрдсэн. Тухайлбал, шилдэг багш судлаач шалгаруулдаг бөгөөд 2020 онд 2 багш шилдэг судлаач багшаар шалгарсан
- Сүүлийн 5 жилийн хугацаанд багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхэд ерөнхий онооны дундаж 91% байгаа бөгөөд энэ нь багшийн ажлын үнэлгээний шалгуураар хангалттай сайн (80-100 оноо) гэж үнэлүүлсэн байна.

4.3 Багшийн хөгжил

Багш нар мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, судалгаа шинжилгээ хийх, магистрын судалгаа удирдах ур чадвараа ахиулахад нь чиглэсэн үйл ажиллагааг системтэй хэрэгжүүлж, боловсролын үйлчилгээнд шинэ арга зүй, инноваци нэвтрүүлэхийг дэмжин урамшуулдаг байна.

Илрэл нотолгоо:

- АШУҮИС-ийн хөгжлийн бодлого /2015-2024/
- АШУҮИС-ийн багшийн алтан дүрэм (АШУҮИС-ийн багш хөгжүүлэх тулгуур баримт бичиг)
- МАУОУС-ийн магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын хамрагдсан урт, богино хугацааны гадаад, дотоодын сургалтууд (гэрчлэх гэрчилгээнүүд)
- МАУОУС-ийн магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын оролцсон эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, семинар (нотлох зураг)

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан/Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн төвөөс багшийн мэргэжлийн болон багшлах ур чадвараа дээшлүүлэх, хөгжүүлэх чиглэлээр эрэлт хээгцээний судалгаа авч богино

хугацааны(мэргэжил дээшлүүлэх) хэрэгцээт сургалтуудыг тогтмол зохион байгуулдаг.

- АШУҮИС-ын багш хөгжүүлэх хөтөлбөрт хамрагддаг.
- Зочин багш урьж судалгааны арга зүй, ёс зүйн чиглэлээрх 3 удаагийн сургалтад хамрагдсан байна.
- Тасралтгүй 10-15 жил ажилласан багш нарт ажиллах хугацаанд 1 удаа 3 сарын цалинтай бүтээлийн чөлөө олгодог. Докторант багш нарын сургалтын төлбөрийн 30 хувийг хөнгөлж дэмжлэг үзүүлдэг,
- Сургуулийн зүгээс 2019 онд ойролцоогоор 30 орчим гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалт болон эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээнд багш, судлаачдыг хамруулж туршлага судлуулах замаар багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны ажилд дэмжлэг үзүүлдэг. МАУОУС-ийн багш нар 2018-2020 оны хооронд дотоодын 17, гадаадын 12 сургалтад хамрагдсан байна.
- Багш нарын гадаад дотоод томилолт, хурал зөвлөгөөн зохион байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.
- Scopus-д бүртгэлтэй сэтгүүлд ЭШ-ний бүтээлээ хэвлүүлж буй багшид дэмжлэг үзүүлж, 2 багшид мөнгөн урамшуулал олгожээ.

Анхаарах асуудал:

- Сургуулиас суурь судалгааны тэтгэлэг олгоход анхаарах

Зөвлөмж:

- Шинэ бүтээгдэхүүний судалгаа, инновацын бүтээгдэхүүн гаргахтай холбоотой тэтгэлэг олгох зардлыг сургуулийн төсөвт суулгах

4.4 Судалгаа ба хөгжил

Багш нар хөтөлбөрийн судлагдахуунтай холбоотой судалгааны ажлыг идэвхтэй хийдэг, шаардлагатай тохиолдолд судалгааны баг бүрдүүлж, магистрантуудыг судалгаанд татан оролцуулдаг байна. Үүний зэрэгцээ үндэсний болон олон улсын эрдэмтдийн баг, сүлжээ, мэргэжлийн байгууллагын идэвхтэй гишүүн байхыг сургуулийн зүгээс дэмждэг байна.

Илрэл нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын SCOPUS-д бүртгэгдсэн бүтээлийн мэдээлэл
- АШУҮИС-ийн МАУОУС-ийн магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын шинжлэх ухааны шинэ туршилт, судалгааны үр дүнгээс гарсан инновацын бүтээгдэхүүн
- АШУҮИС-ийн МАУОУС-ийн магистрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын патент, ашигтай загварын гэрчилгээ
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч багш нарын боловсруулж батлуулсан стандарт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- УАУ-ны эрдэм судлалын үр дүнд бүтээгдсэн шинэ эм БИБ гарган авч гарааны компани түшиглэн үйлдвэрлэлд нэвтрүүлэх боломж нээгдсэн байна.
- Патент, ашигтай загварын гэрчилгээ-9
- Стандартын төрөл-3 байна.

- Сүүлийн 5 жил төсөлт ажил нийт 23 байна.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсронгуй болгох ажлыг үе шаттай хэрэгжүүлж ирсэн.
- Гадаадын 11 их сургуультай багш оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж хамтран ажилладаг.
- 2016-2020 оны хугацаанд Уламжлалт анагаах ухааны чиглэлээр шинжлэх ухааны магистрын зэрэг нийт 67 судлаач хамгаалсан бөгөөд УАУ-ны онолын судалгаа, түүх эх сурвалжийн судалгааны чиглэлээр нийтдээ 19, Уламжлалт эмийн түүхий эд, эм тангийн фармакологийн судалгааны чиглэлээр нийтдээ 31, УАУ-ны оношлогоо, эмчилгээ эмнэлзүйн чиглэлээр 14 судлаач судалгааны ажил бичиж зэрэг хамгаалсан.
- Эрдэм шинжилгээний бүтээлийн хувьд сүүлийн 3-4 жилийн хугацаанд үндэсний болон олон Улсын нэр хүнд бүхий хэвлэлд нийт 405 бүтээл хэвлүүлсэн байна
- 2016-2019 онд 118 ЭШӨ монгол хэлээр, 46 өгүүлэл гадаад хэлээр хэвлэгдсэнээс 17 өгүүлэл өндөр IF-тэй сэтгүүлд хэвлэгдсэн байна.
- 2016-2019 онд 146 эрдэм шинжилгээний илтгэл дотоодод, 95 илтгэл гадаадад хэвлэгдсэн байна.
- Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэгч багшийн төслөөс магистрантын грант гардаг байна.

Анхаарах асуудал:

Гадаадын хамтарсан төсөлт хөтөлбөрүүдийг улам нэмэгдүүлэх түүгээр дамжуулан судалгааны өөрийн баазыг бэхжүүлэх, эрдэм судлалын ажлын үр дүнгээр бий болсон инновацын бүтээгдэхүүнүүдийг зах зээлийн эргэлтэд оруулж үйлдвэрлэлд шилжүүлэх.

Зөвлөмж:

- Судалгаа эрдэм шинжилгээ, төсөл хөтөлбөрт магистрантурт суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх
- Суралцагсдад сургалтын төлбөрөөс тодорхой хувийг судалгааны зардалд эргүүлэн олгодог байх, сайн суралцагч нарыг урамшуулах, грант олгох төсөвийг суулгах

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Нөөц ба санхүүжилт

Суралцахуйн зорилтот үр дүнд хүрэх, судалгааны ажлыг чанартай хийхэд шаардагдах нөөцийг бүрдүүлж, нөөцийн хуваарилалт болон гүйцэтгэлийг хянах, хөтөлбөрийн байнгын хөгжлийг дэмжих санхүүгийн хангалттай эх үүсвэртэй байна.

5.1 Сургалт, судалгааны орчин

Тухайн хөтөлбөр, шинжлэх ухааны чиглэлээр магистрант идэвхтэй суралцах, судалгаа хийх анги танхим, лаборатори, зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмжийг бүрдүүлж, багш, суралцагчдын сэтгэл ханамжид үндэслэн сайжруулдаг байна.

Илрэл нотолгоо:

- **Тэнхим:** МАУОУС-ийн магистрийн хөтөлбөрийн хэрэгжилтэнд 2020 оны 09 сарын байдлаар мэргэжлийн 6 тэнхим, Био-АС-ийн 12 тэнхим, НЭМС-ийн 4 тэнхим, АУС-ийн 16 тэнхим оролцдог.

- **Лаборатори:** АШУҮИС-ийн үндсэн мэргэжлийн суурь хичээлийн түшиц 19 лабораториудыг судалгааны бааз болгон ашигладаг. Олон улсын жишигт нийцүүлсэн сургалт судалгааны лабораториудын хүчин чадлыг жил бүр төлөвлөгөөтэй сайжруулдаг. Сургалтын лабораторийн түшиц 10 байгууллагуудад судлаачид туршилт судалгаагаа явуулдаг.
- **Эмнэлэг, сувилал:** Эмнэлзүйн судалгааны сургалтын баазад 60 ортой МУАҮҮТ эмнэлэг, Эрхэс сувилалтай.
- **Ур чадварын төв:** Эмнэлзүйн 3 ур чадварын төвд сургалтын үйл ажиллагааг явуулдаг
- **Сургалтын орчин:** МАУОУС-ийн 1 суралцагчид ноогдох сургалтын орчны хэмжээ 2015 онд 2.5 мкв байсан бол дээрх сургалтын бааз болсон барилгууд шинээр ашиглалтад орсноор хичээлийн байруудын барилгын ашигтай талбай 17140 мкв, сургуулийн түшиц эмнэлэг, клиник дээр байгаа хичээлийн өрөөнүүдийн талбай 3240 мкв, цөм лаборатори 400 мкв бүгд 20780 мкв байгаа бөгөөд 1 суралцагчдад 3.5 мкв талбай ноогдох болсон нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандарт нийтлэг шаардлагын нормын хэм хэмжээг бүрэн хангахуйц болж нэмэгдсэн.
- Суралцагчдын эрүүл аюулгүй орчныг бүрдүүлэх, анги танхимийг сайжруулахад төлөвлөгөө гарган хөрөнгө зарцуулдаг.
- **Тоног төхөөрөмжийн байдал:** 2017 онд зайн сургалтын төв, 2018 онд 10 нэр төрлийн 10 ширхэг сургалтын компьютер, Смарт индэр, Телеконференцийн өрөө, бусад анги танхимыг засварлаж тохижуулж сургалтын орчин нөхцөлийг сайжруулсан байна. 2019 онд багш ажилчдын 44 нэр төрлийн 850 тавилга эд хогшил, 61 төрлийн 300 ширхэг компьютер, тоног төхөөрөмжөөр хангасан.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 онд МАУОУС нь 3.901.82 мкв өөрийн шинэ байртай болсон.
- 1 суралцагчдад 3.5 мкв талбай ноогдох болсон нь дээд боловсролын байгууллагад тавигдаж буй стандарт нийтлэг шаардлагын нормын хэм хэмжээг бүрэн хангахуйц болж нэмэгдсэн.
- “Зүү төөнө засал”, “Бариа засал”, “Заслын ур чадварын төв” гэсэн 3 сургалтын ур чадварын төв тухайн сургууль дээр байгаа нь эмнэлзүйн судалгаа хийх магистрантуудад ач холбогдолтой байна.
- Жил бүр тоног төхөөрөмж сургалтын орчиныг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Анхаарах асуудал:

- АШУҮИС-ийн түшиц 19 лабораториудыг МАУОУ-ын магистрантуудад ашиглах хүртээмжийг нэмэгдүүлэх, ялангуяа цөм лабораторийн ашиглалтыг нэмэгдүүлэх
- Лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэх магистр болон судлаачдын судалгааны арга зүйн чадамжийг нэмэгдүүлэх
- Ур чадварын 3 төв дээр хийгдэж буй процедур, ажилбарт эрүүл мэндийн системд хэрэгжиж байгаа тушаал, зааврын биелэлтийг хангуулах, суралцагчийг ажлын зөв дадал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар аюулгүй байдлыг хангаж

үйлчилгээ үзүүлэхэд чиглүүлэх, дадуулах, дадалтай болгох тал дээр анхаарч ажиллах

- Эрдэм шинжилгээний төвүүд, хүрээлэнгүүдтэй хамтын ажиллагаагаар суралцагчдын судалгааны ажлыг хийдэг ба хүрээлэнгүүдтэй албан ёсны гэрээ байгуулж, магистрантуудын судалгаа хийх нөхцөлийг баталгаажуулах

Зөвлөмж:

- МАУОУ сургууль нь өөрийн бичил туршилт судалгааны лабораторийг бий болгох
- Магистрантын идэвхийг дэмжих зорилгоор урамшуулал олгох журмын хэрэгжилтэнд анхаарах

5.2 Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн

Хичээл тус бүрээр үндсэн сурах бичиг, сургалт, судалгааны хэрэглэгдэхүүнийг хангалттай бүрдүүлж, судалгааны ажилд шаардлагатай мэдээлэл, үр дүнгүүдийг багш, магистрантууд хэвлэмэл болон цахим хэлбэрээр нээлттэй ашигладаг байна.

Илрэл нотолгоо:

- **Үндсэн сурах бичиг:**
- 2020 оны 9 сарын байдлаар АУТН санд Уламжлалт анагаах ухааны чиглэлээр хэвлэмэл ном монгол хэлээр 122 нэр төрлийн 651 ширхэг, Англи хэл дээр 9 нэр төрлийн 19 ширхэг ном сурах бичиг байна.
Судалгаа шинжилгээний үр дүнг гаргадаг сэтгүүл монгол хэл дээр 1 нэр төрлийн 15 дугаар, цахим ном 207 ширхэг байгаагаас Монгол-15, Англи 202, Орос 6 ширхэг бүтээл байна.
- Цахим мэдээлэлийн санд- Ebook-56, E Journal -19 байна.
- Эрдмийн зэрэг хамгаалсан бүтээл нийт-204. Үүнээс Шинжлэх ухааны докторын диссертаци /Sc.D/-1, Докторын / Ph.D/- 48 ширхэг, магистрын тезис хураангуй – 155 бүтээл байна.
- **Сургалт сургалтын хэрэглэгдэхүүн:**
- **Номын сан:** 2015 онд- АШУҮИС нь 3.099.545.476 төгрөгийн өртөгтэй, 848 мкв талбайтай 7 давхар 336 уншигчийн суудалтай “Анагаах ухааны төв номын сан”-г ашиглалтанд оруулсан байна.
- АУТНС уншлагын 6 танхим 602 суудалтай MNS 5472:2007 стандартад нийцсэн номын санг ажиллуулж байна. Үүнээс Эрдэм шинжилгээний уншлагын танхим, гадаад ном, тогтмол хэвлэлийн уншлагын 3 танхимтай, 56 суудалтай 3000 гаруй доктор, магистр, бакалаврийн бүтээл, нэвтэрхий толь, лавлагааны материалтай.
- 2015 онд цахим номын сангийн техник тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилсэн. 25 компьютер, 30 iPad болон бусад тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 2 цахим уншлагын танхимтай. Scansnap1500 төхөөрөмж зөөврийн scanner-г ашиглаж байна.

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан /Хэсэгчлэн хангасан/Хангаагүй

Онцлог зүйл/Туршлага:

